

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

### БАЙГУУЛЛАГЫН ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ТАВИГДАХ СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛД

Э.Энхчимэг\*

\* УИХ дахь АН-ын бүлгийн хэвлэлийн төлөөлөгч, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

**Түлхүүр үг:** хэвлэлийн төлөөлөгч, сэтгүүлчийн үүрэг, пресс релиз, мэдээллээр "засаглахуй", мэдээлэл харилцааг зохион байгуулах

**С**этгүүлч нь бие даасан төдийгүй аль ч салбарт ажиллаж болох хамгийн олон талт мэргэжил гэгддэг. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч нэг салбараас нөгөөд, нэг газраас өөр рүү шилжин шинэ ажил үүрэг авсан ч мэдээлэл түгээх, зохион байгуулах мөн чанар нь хэвээр байдаг.

Даяарчлагдсан, мэдээллийн, мэдээлэл харилцааны гэх орчин үеийн нийгэмд төр, аж ахуй нэгж, байгууллага, бизнес эрхлэгч, улс төрийн зүтгэлтэн гэх зэрэг субъектууд өөрийн тухай болон үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийхээ талаарх мэдээллийг төлөвлөж, бэлтгэн боловсруулах, мэдээллийн хэрэгсэл, сувгуудаар хэрэглэгч, харилцагчдад хандсан PR мэдээллийг хүргэх, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай нүүр тулсан билээ. Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахад тухайн салбарын мэргэжилтнүүд бус сэтгүүлч бидний мэргэжлийн ур чадвар

зайлшгүй хэрэгтэйг тэд нэгэнт ойлгосон бөгөөд хэвлэлийн төлөөлөгчийн тусламжтайгаар дээрх үйл ажиллагааг явуулж байгаа юм.

Байгууллагын сэтгүүлч буюу хэвлэлийн төлөөлөгч хэмээх ажлыг сэтгүүлчдийг дууддаг, мэдээ дамжуулдаг нэгэн төдийхнөөр ойлгож байсан нь саяхан. Тэгвэл энэхүү ажил нь бие даасан, үнэ цэнтэй, өөрийн гэсэн үүрэг хариуцлагатай алба болохыг мэдээлэл харилцаа хөгжих тусам ойлгосоор байгаа нь сайшаалтай.

Тэгвэл онолын хувьд хэвлэлийн төлөөлөгч хэмээх ойлголтыг:

- “Spokesperson - Хэвлэлийн төлөөлөгч гэдэг нь хэн нэгний өмнөөс төлөөлөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээх үүрэг бүхий мэргэжилтэн юм”<sup>1</sup>.

- “Хэвлэлийн төлөөлөгч гэдэг нь төлөөлөн буй байгууллага, хувь хүний талаарх албан ёсны мэдэгдэл, мэдээллийг дамжуулагч юм”<sup>2</sup>.

- "Нэг талаас удирдлагаа нөгөө талаас нийгэм олон нийтийг мэдээллээр хангагч төдийгүй, эх сурвалж, судлаач, уран бүтээлчийн аль

ч түвшинд мэдлэг чадвар бүхий мэргэжилтэн”<sup>3</sup>.

- “Хэвлэлийн төлөөлөгч нь хувь хүний үүднээс хандах бус танай байгууллагын төлөөлөгч, та бүхний дуу хоолой болон харьцах ёстой”<sup>4</sup>.

- “Олонд танигдсан алдар нэртэй хүмүүс, эсвэл ямар нэгэн бүтээгдэхүүн, үйл хэргийн мэдээлэл нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр олон нийтийн дунд хоногшин үлддэг. Үүнийг хэвлэлийн төлөөлөгч гүйцэтгэдэг”<sup>5</sup>.

- “Сэтгүүл зүй, олон нийтийн харилцаа, харилцаа холбооны салбарт хэвлэлийн төлөөлөгчид чухал үүрэгтэй мэргэжилтнүүд байдаг”.

- Хэвлэлийн төлөөлөгч гэдэг нь тухайн субъектын мэдээлэл харилцааны мэргэжилтнийг хэлж байгаа юм. Тодруулбал, нэгэн толь бичигт мэдээлэл харилцааны мэргэжилтэн гэдгийг “дамжуулж байгаа зүйлийн мөн чанарыг гаргагч” гэжээ гэх зэргээр тодорхойлжээ.

Мөн Канадын нэрт профессор, маркетинг менежментийн томоохон төлөөлөгч Хэнри Минцберг хэвлэлийн төлөөлөгч хэмээх ойлголтыг гүйцэтгэх чиг үүрэгтэй нь уялдуулан дараах сонирхолтой байдлаар тайлбарласан байна.

Х. Минцбергийн онол



Үүнийг Минцбергийн онол гэж нэрлэдэг бөгөөд хэвлэлийн төлөөлөгч нь гэнэтийн буюу онцгой нөхцөл байдлаас гарах хэвлэлийн төлөвлөгөөтэй байх ёстой, түүнийхээ “зах зээл”-ийг зөв мэдэрч, зөв үед нь PR хийж мэдээлэл өгөх ёстой аж.

Хэвлэлийн төлөөлөгчийн ажил нь өөрийн гэсэн хэм хэмжээ, онцлогийг агуулсан өвөрмөц үйл явц, харилцаа бөгөөд тодорхой зорилгын дор эерэг нөлөөллийн орчныг бий болгон

төлөвшүүлэх үүрэг бүхий “мэдлэг, туршлага, сэтгэлгээний үйл хэрэг”<sup>6</sup> юм.

**Хэвлэлийн төлөөлөгчийн ажил нь өөрийн гэсэн хэм хэмжээ, онцлогийг агуулсан өвөрмөц үйл явц, харилцаа бөгөөд тодорхой зорилгын дор эерэг нөлөөллийн орчныг бий болгон төлөвшүүлэх үүрэг бүхий “мэдлэг, туршлага, сэтгэлгээний үйл хэрэг” юм.** Тэгвэл хэвлэлийн төлөөлөгч нь дараах нийтлэг чиг үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

1. Тухайн субъектын болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг бэлтгэн боловсруулах буюу пресс-релиз бэлтгэх,

2. Өөрийн байгууллага болон түүний удирдлагын талаарх олон нийтийн ухамсар, санаа бодолд буй дүр төсөөллийг мэдэж байх,

3. Тухайн салбар асуудлын талаарх олон нийтийн санаа бодол, хандлага, үнэлэмж, байр суурийг тодорхойлох,

4. Үйл явдал, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, үр нөлөөтэй хүргэх түгээлтийн арга хэлбэрийг сонгох (мэдээллийн багц, дам тайлбар, шууд тайлбар, мэдэгдэл, хэвлэлийн бага хурал, шуурхай уулзалт, зангиагүй уулзалт, ярилцлага, мэтгэлцээн гэх мэт),

5. Харьцуулсан болон хэвлэл мэдээллийн дүн шинжилгээ хийх,

6. Олон нийтийг мэдээллээр хангах хөтөлбөр боловсруулж, харьяа байгууллага, агентлаг, хэлтэс, тасгуудын ажлыг уялдаа холбоотойгоор удирдаж явуулах,

7. Байгууллагын мэдээ, мэдээллийн архив бүрдүүлэх<sup>7</sup> зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг.

Хэвлэлийн төлөөлөгч дээрх чиг үүргийг гүйцэтгэхэд хувь хүний ажлын бүтээмж, ур чадвараас гадна сэтгүүлчийн мэргэжлийн шаардлага зайлшгүй тавигддаг. Учир нь хэвлэлийн төлөөлөгчийн хамгийн гол гүйцэтгэх ажил бол пресс-релиз буюу мэдээллийн хуудас бэлтгэх юм. Мэдээлэл нь өөрөө имидж бүрдүүлж, паблицити буюу нэр хүнд олж авах, олонд танил болох, нийтийн өмнө гарах, сурталчлах, ажил хэргийн холбоо тогтооход нөлөөлдөг. Иймээс хэвлэлийн төлөөлөгчийн бэлтгэсэн мэдээллийн хуудсыг сэтгүүлчид мэдээллийн нэгэн эх сурвалж, ишлэл, нэмэлт баримт болгон ашигладаг. Мэдээллийн хуудсан дахь мэдээллийн гарчиг товч, хоёрдмол утгагүй байх ёстой. Мэдээллийн үндсэн хэсэг нь 5W&1H асуултад хариулт өгөхүйц агуулгатай байна.

Тухайн байгууллагын хэвлэлийн төлөөлөгч нь сэтгүүлч биш буюу мэргэжлийн бус хүн зарим тохиолдолд ихээхэн эрсдэл тулгардаг. Үүнийг Хууль зүйн яамны харьяа зарим агентлаг, байгууллагын хэвлэлийн төлөөлөгчдийн жишээн дээр тайлбарлавал:

	Харьяа агентлаг, байгууллага	Хэвлэлийн ажилтны тоо	Хэвлэлийн ажилтны мэргэжил	Цахим хуудас	Дүн шинжилгээ
	Цагдаагийн ерөнхий газар	7	Сэтгүүлч Найруулагч Зураглаач Эрх зүйч	<a href="http://www.police.gov.mn/">http://www.police.gov.mn/</a>	Хэвлэл мэдээллийн төв ажилладаг. Хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хэвлэлд имижээ бүрэн тодорхойлж чаддаг. Хэвлэлийн төлөөлөгч нь чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадаж байгаа. Мэдээллийн хувьд Улаанбаатар хотын цагдаагийн газар, цаг үе,

Хууль зүйн яам					<p>үйл явдал, сэрэмжлүүлэг, статистик мэдээ, гэмт хэргийн мэдээ, спорт мэдээ, соёл урлаг, 11-11 төв, ярилцлага, нийтлэл гэсэн булан дор бэлтгэдэг.</p> <p><b>Давуу тал:</b> Байнгын "онцгой" байдалд ажилладаг учир гэнэтийн нөхцөлд байдалд бэлэн байж мэдээллийг зөв тийш залж чаддаг.</p>
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	3	Сэтгүүлч	<p><a href="http://cd.gov.mn/mn/">http://cd.gov.mn/mn/</a></p>	<p>Шинэ мэдээ, их үзсэн, мэдээний архив: ярилцлага, видео мэдээ булан дор бэлтгэдэг.</p> <p>Байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнаар мэдээлэл өгүүлдэг. Зарим тохиолдолд хэвлэлийн мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн мэдээлэл өгдөг. Байгууллагын дүр бүтээх ажлыг сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар гарган сайн хийж байна. Жишээлбэл: хоригдлуудын хүмүүжил, ажил эрхлэлтийн талаар зэрэг сурталчилгаа явуулж байна. Тэдгээрээс ярилцлага авч нийтэлсэн.</p>
Хууль зүйн яам	Хил хамгаалах ерөнхий газар	6	Сэтгүүлч, зураглаач	<p><a href="http://bpo.gov.mn/">http://bpo.gov.mn/</a></p>	<p>Байгууллагын цахим хуудсыг хамгийн сайн хөтөлж байгаа гэж дүгнэсэн. Цаг үеийн мэдээ, ярилцлага, фото мэдээ, видео мэдээ, шинэ ном, сэтгүүлийн мэдээг түгээдэг. Мэдээ мэдээлэл түгээхээс гадна "Хилчин" хэмээх дүрийг бүтээж чаджээ. 14 хоног бүр хилийн сурвалжлага нийтэлдэг. Мөн "Эх орны манаа", "Хилчин" сэтгүүлийг хэвлэлийн ажилтнууд нь эрхлэн гаргаж байна. Мөн теле студитэй учир хэвлэлийн ажилтнууд нь хилийн шалган нэвтрүүлэхээс өөрсдөө нэвтрүүлэг бэлтгэдэг.</p> <p><b>Шүүмж:</b> Хил дээр олон цэрэг амиа алдсан талаарх мэдээлэл цахим ертөнцөөр тарахад, ХХЕГ-ын дарга, генерал Ш.Лхачинжав хариу мэдэгдэл хийж хэвлэлийн хурал хийв. Энэ ажлыг хэвлэлийн алба нь зохион байгуулсан ч хэд хэдэн алдаа гаргасан. ХХЕГ-ын хэвлэлийн албанд гэнэтийн нөхцөлд бэлэн байх төлөвлөгөө байсангүй.</p>

Хууль зүйн туслал-цааны төв	1	Эдийн засагч	<a href="http://www.legalaidcenter.mn/">http://www.legalaidcenter.mn/</a>	Цахим хуудас ажиллагаагүй.
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	1	Сэтгүүл зүйн сургалтад хамрагдсан эрх зүйч	<a href="http://www.nifs.gov.mn/">http://www.nifs.gov.mn/</a>	Мэдээ, мэдээлэл булан дор мэдээллээ байршуулдаг. Мөн хэвлэл нийтлэл булан дор хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан өөрийн байгууллагатай холбогдох мэдээллийг холбож өгсөн байна. Шүүмж: бүх мэдээний гарчигт "" тавьсан байна. Найруулга зүйн болон зөв бичгийн дүрмийн зарим алдаанууд ажиглагдлаа. Мөн сүүлд нийтлэгдсэн 15 мэдээнээс 12 мэдээний гарчгийг ижилхэн төгсгөсөн. <b>Жишээлбэл:</b> байгуулагдлаа, гарын үсэг зурлаа, шагнагдлаа, орлоо, олгогдлоо, эзэллээ гэх мэтчилэн. Хэвлэл мэдээллийн байгууллагад зөвхөн удирдлага нь мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулдаг.
Тахарын ерөнхий газар	1	Сэтгүүлч	<a href="http://takhar.gov.mn/">http://takhar.gov.mn/</a>	Мэдээ булан дор мэдээллээ байршуулдаг. Зарим мэдээний гарчигт "" тавьсан, найруулга зүйн болон зөв бичгийн дүрмийн алдаа ажиглагдав.

Хүснэгтээс үзвэл, байгууллагын хэвлэлийн төлөөлөгчийн албанд мэргэжлийн бус ажилласнаар хэвлэлд өөрийн байгууллагаа төлөөлж чадахгүй байна. Ингэснээр хэвлэлийн төлөөлөгчийг зөвхөн зохион байгуулагчийн үүрэгтэй болгож байгаа юм. Мөн хэл зүй, найруулга зүйн алдаа, зөв бичгийн дүрмийн алдааг дэлгэрүүлж байна.

Ерөнхийдөө хэвлэлийн төлөөлөгчийн ажил нь шинэ баримт, үзэл бодол, байр суурийг хурдан эсвэл богино хугацаанд өөрийн болгож, олон нийт нийгэмд үр нөлөөтэй, оновчтой түгээх ажлыг зохион байгуулахад оршдог учраас сэтгүүлчийн ур чадвар зайлшгүй шаардагддаг. Түүнчлэн хэвлэлийн төлөөлөгч нь хамтын удирдлагын идэвхтэй гишүүн, зөвлөгч, гүйцэтгэгч байх ёстой юм.

### Дүгнэлт

Мэдээллээр дамжуулан засаг төр, байгууллага, хувь хүмүүс өөрсдийн имижийг бүрдүүлж байгаа өнөөгийн нийгэмд хэвлэлийн төлөөлөгч онцгой үүрэг гүйцэтгэж байна. Олон нийтэд өөрийн үйл ажиллагаа ба санаа бодлоо таниулж, тодорхой хэмжээгээр олон нийтийн хандлага, үйлдэлд нөлөөлөх үр дүнг хүсч зорьж байгаа тэд хэвлэлийн төлөөлөгч гэх сэтгүүл зүйн мэргэшсэн ажилтнуудтай хамтран ажиллах зайлшгүй нөхцөл бүрэлдэн бий болжээ.

Мөн дээрх тайлбар болон зарим судалгаанаас үзвэл "Хэвлэлийн төлөөлөгч гэдэг нь *тухайн субъектыг албан ёсоор төлөөлөх үнэн бодитой мэдээлэл бэлтгэж, олон нийтийг мэдээлэл хүлээн авах ямар хэсэгт*

байгааг олж тогтоон, тэдгээрт шуурхай мэдээлэл түгээх мэргэжилтэн юм" гэж тодорхойлж болох юм.

### Ишлэл

<sup>1</sup> *Goodman, Michael B.* 1998. *Corporate communications for executives*. Albany, N.Y.: State University of New York Press. p. 13.

<sup>2</sup> Cambridge Academic Content Dictionary © Cambridge University Press

<sup>3</sup> *Болд-Эрдэнэ Б., Өнөрбаяр Г.* 2011. Төрийн байгууллагын мэдээлэл харилцаа. УБ. 151 дэх тал

<sup>4</sup> *Ариунбат Л.* 2014. Мэдээлэл харилцааны ухаан. УБ. 14 дэх тал

<sup>5</sup> *Gemma Halder.* 2012. Spokesperson.

<sup>6</sup> *Болд-Эрдэнэ Б., Өнөрбаяр Г.* 2011. Төрийн байгууллагын мэдээлэл харилцаа. УБ. 150 дахь тал

<sup>7</sup> Мөн тэнд, 152 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Ариунбат Л.* 2014. Мэдээлэл харилцааны ухаан. УБ.

2. *Болд-Эрдэнэ Б., Өнөрбаяр Г.* 2011. Төрийн байгууллагын мэдээлэл харилцаа. УБ.

3. *Болд-Эрдэнэ Б.* 2005. Олон нийтийн харилцаа. УБ.

4. *Зулькафил М.* 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

5. *Зулькафил М.* 2012. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал.

6. 2015. Alternatives on media content journalism and regulation.

7. *John Vivian.* 2010. Media of Mass Communication. (The 10<sup>th</sup> edition)

8. *John Vivian.* 2012. Media of Mass Communication. (The 11<sup>th</sup> edition).

9. *Antony Young.* Brand Media Strategy: Integrated Communications Planning in Digital Era

10. *Goodman, Michael B.* 1998. *Corporate communications for executives*. Albany, N.Y.: State University of New York Press.

### Abstract

Spokesperson is playing important role in the world where government, organization and individuals are building their image through the media. They are cooperating with spokesperson which is a profession of journalism due to their intention of raising his opinion and actions; and influencing attitude of the mass for some purpose.